



15

**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 007

Баян-Өндөр сум

Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, "Журам батлах тухай" Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 63/104 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2, 3 дугаар заалт, "Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний журмыг шинэчлэн батлах тухай" газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн A/27 дугаар тушаалын 9.1.7.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:


1."Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, ур чадварын нэмэгдлийн хувь, хэмжээг сар бүр тушаалаар баталгаажуулж ажиллахыг архив, бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтан (Ч.Болдцэцэг)-д даалгасугай.

3.Ур чадварын нэмэгдлийг жил бүр төсөвт тусгуйлж ажиллахыг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д үүрэг болгосугай.

4.Газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн A/79 дүгээр тушаалыг хүчингүйд тооцож, энэ тушаалыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлсүгэй.

ДАРГА



Д.ДЭЛГЭРБАЯР

(D)/2025/Албан хэрэг/Тушаал-25
612501042

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 02 дугаар сарын 03...-ны өдрийн
10:07...дугаар тушаалын хавсралт

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ АЛБАН
ХААГЧДАД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

1. Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зохих үүрэг гүйцэтгэдэг түгээмэл мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү журмыг баримтална.

2. Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд тогтмол сайн гүйцэтгэдэг буюу бусдаас илүү идэвхи санаачилга, өндөр үр дүнтэй ажиллаж байгаа түгээмэл мэргэжлийн албан хаагчдад дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан ур чадварын нэмэгдэл сар бүр олгоно.

№	Албан тушаал	Шалгуур, үзүүлэлт	Оноо
1.	тогоол шийдвэрийн биелэлт, хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.албан үүрэгтэй нь холбоотой сарын мэдээ, тайланг хугацаанд нь гаргасан байх;	5
		3.байгууллагын үйл ажиллагааны сарын төлөвлөгөө, тайланг гаргаж, үнэлгээ хийсэн байх;	5
		4. http://www.shilen.gov.mn/ хэрэгжилтийг хангуулсан байх;	5
		5.и-офис программа ашиглалт;	5
2.	цахим сан, статистик мэдээ, сурталчилгаа хариуцсан ажилтан	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.албан үүрэгтэй нь холбоотой сарын мэдээ, тайланг хугацаанд нь гаргасан байх;	5
		3.байгууллагын вэб хуудасны мэдээллийг тогтмол хөтөлсөн байх;	5
		4.байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг нийтэд сурталчилсан байх;	5
		5.и-офис программа ашиглалт;	5
3.	спортын мэргэжилтэн	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.албан үүрэгтэй нь холбоотой сарын мэдээ, тайланг хугацаанд нь гаргасан байх;	5
		3.зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг нийтэд сурталчилсан байх;	5
		4.арга хэмжээний сарын статистик мэдээг гаргасан байх	
		5.и-офис программа ашиглалт;	5
4.	ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.сарын гүйцэтгэлийн мэдээг гаргаж, ил тод байршуулсан байх;	5
		3.үндсэн үйл ажиллагааны орлого, зарлагын тайланг байгууллагын цахим группт байршуулсан байх;	5
		4.хөрөнгийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж, батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байх;	5
		5.и-офис программа ашиглалт;	5
5.	архив, бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтан	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.албан үүрэгтэй нь холбоотой сарын мэдээ, тайланг хугацаанд нь гаргасан байх;	5
		3.байгууллагын албан хэрэг хөтлөлтийн тайлан мэдээг гаргасан байх;	5
		4.хүний нөөцтэй холбогдолтой тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байх;	5
		5.и-офис программа ашиглалт	5
6.	биеийн тамирын зохион байгуулагч	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.албан үүрэгтэй нь холбоотой сарын мэдээ, тайланг хугацаанд нь гаргасан байх;	5
		3.зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг нийтэд сурталчилсан байх;	5
		4.спортын арга хэмжээний сарын статистик мэдээг гаргасан байх;	5

		5.и-офисс программ ашиглалт;	5
7.	нярав	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.жижуурний орлогын төлөвлөгөөг сар бүр тооцсон байх;	5
		3.санхүүгийн анхан шатны баримтыг журмын дагуу хөтөлж, мэдээ тайлант хугацаанд нь танилцуулсан байх;	5
		4.цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол зохион байгуулсан байх;	5
		5.эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, зөрчилгүй ажилласан байх;	5
8.	цахилгаанчин, сантехникч-жижуур	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.гарсан эвдрэл, гэмтлийг түргэн шуурхай, чанартай засварлах;	5
		3.материалын тооцоо гаргаж, хэмнэлттэй ажилласан байх;	5
		4.орлого тушаасан байх;	5
		5.жижуурний хуваарийн дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэсэн байх;	5
10.	жолооч-жижуур	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.автомашины бэлэн байдлыг хангаж, урсгал засвар, цэвэрлэгээ, үйлчилгээг сард 1 удаа хийж, биелэлт гаргасан байх;	5
		3.орлого тушаасан байх;	5
		4.зөвшөөрөлгүй автомашин хэрэглэх, бусдад шилжүүлэхгүй байх, албан томилот, уралдаан, тэмцээнд явахдаа зөрчил гаргаагүй үйлчилсэн байх;	5
		5.жижуурний хуваарийн дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэсэн байх;	5
11.	үйлчлэгч	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.цэвэрлэгээний материалыг норм, зориулалтын дагуу ашигласан байх;	5
		3.сард 1 удаа ариутгал, халдвартгүйжүүлэлт хийсэн байх;	5
		4.цэвэрлэгээний хэрэглэл, материалыг ажил дууссаны дараа ариутгаж, цэвэрлэсэн байх;	5
		5.ажлын хувцас, хэрэглэлийг журмын дагуу өмссөн байх;	5
12.	жижуур	1.ажлын цаг ашиглалт;	5
		2.жижуурний хуваарийн дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэсэн байх;	5
		3.орлого тушаасан байх;	5
		4.хариуцсан талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийж, зөрчилгүй ажилласан байх;	5
		5.эд хөрөнгийн зөрчилгүй ажилласан байх;	5

3. Ур чадварын нэмэгдлийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 25 хувиас ихгүй байна.

үнэлэх, дүгнэх	оноо	цалинд ногдох хувь	тайлбар
5 шалгуур	25 оноо	25%	-нэг шалгуур, үзүүлэлтийн гүйцэтгэл 50%-90%
үзүүлэлтэд ногдох оноо	20 оноо	20%	хүртэл 2,5 оноо, 90%-ээс дээш бол 5 оноо,
	15 оноо	15%	50%-аас доош бол оноо өгөхгүй
	10 оноо	10%	-10-аас доош оноо авбал нэмэгдэл олгогдохгүй.

4.Ур чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд сарын албан тушаалын үндсэн цалингаас тооцож олгоно.

5.Ур чадварын үнэлгээг хүний нөөцийн ажилтан дүгнэж, дарга баталгаажуулж, сар бүр цалингийн санд багтаан олгоно.

6.Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно.

---оо---

